**“ЦЭНХЭРИЙН ХӨНДИЙ” ХХК-ИЙН УЛААНБААТАР ХОТЫН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 14-Р ХОРООНЫ НУТАГ ДАХЬ БОГДХАН УУЛЫН ДЦГ-ЫН ТҮРГЭНИЙ АМАНД “АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЦОГЦОЛБОР” БАЙГУУЛАХ ТӨСЛИЙН**

# 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

РД: 6208592

УЛААНБААТАР ХОТ
2025 ОН

# *ГАРЧИГ*

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ ....................1
1.1 Төслийн зорилго: ....................3
1.2 Төслийн үндэслэл ....................3
1.3 Төслийн байршил:....................3
1.4 Төслийн товч тодорхойлолт, хүчин чадал :....................6
1.5 Төсөл хэрэгжих орчны дэд бүтцийн хөгжлийн байдал....................8
1.5.1 Цахилгаан хангамж ....................8
1.5.2 Цэвэр усан хангамж....................9
1.5.3 Дулаан хангамж ....................10
1.6 Тэрбум мод ....................12
ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ....................13
2.1 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний цар хүрээ ....................13
2.1.1 Менежментийн төлөвлөгөөний зорилго, зорилт....................13
2.1.2 БОМТ-ний хамрах хүрээ ....................13
2.1.3 БОМТ-ний нийт зардал, түүний бүтэц....................13
2.2 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө ....................14
2.3 Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө ....................15
2.4 Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө ....................16
2.5 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө ....................16
2.6 Хог хаягдлын менежмент....................17
2.7 Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр ....................17
2.8 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө ....................19
2.9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө....................19

## *ТАЙЛАНД ОРСОН ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЭЛИЙН ЖАГСААЛТ*

Хүснэгт 9. Төсөл хэрэгжүүлэгчийн ерөнхий мэдээлэл....................3
Хүснэгт 10. Газарзүйн солбицол....................4
Хүснэгт 11. Ахуйн ундны усны тооцоо....................9
Хүснэгт 12. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд дараагийн 5 жилд тарих модны тооцоолол ....................12
*Хүснэгт 7. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө*....................14

*ТАЙЛАНД ОРСОН ЗУРГАН МЭДЭЭЛЭЛИЙН ЖАГСААЛТ*

*Зураг 4. Төсөл хэрэгжих талбайн байршлын тойм зураг* ........................................................5
Зураг 5. Усны нөөцийн сав, Цахилгаан тоолуурын самбар, Ус халаагч бойлероор шийднэ. .........................................................................................................................................10

## НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

<u>Төслийн нэр</u> : “**Аялал жуулчлалын цогцолбор** ” байгуулах төсөл

Зураг 1. Төслийн ерөнхий төлөвлөгөө



**1.1 Төслийн зорилго:**

Энэхүү төслийн гол зорилго нь гадаад дотоодын жуулчдыг хүлээн авах, зочдын ая тухтай амрах нөхцөл боломжийг бүрдүүлэх, олон улсын болон дотоодын хурал зөвлөгөөн, төсөл семинар, зочдод дахин ирэх хүсэл сонирхол төрүүлэх, түүнчлэн бизнесийн таатай орчин бүрдүүлэх өндөр зэрэглэл бүхий аялал жуулчлалын үйлчилгээ явуулж, өөрийн оронд энэ салбарыг хөгжүүлэх, хүрээлэн буй орчныг цэвэр, байгаль орчинд халгүй технологиор тоноглогдсон үлгэр жишээ экологийн боловсрол олгох сургалт сурталчилгааны төв, өндөр зэрэглэлийн амрагчдын цогцолбор, байгууламж байгуулахад оршино.

**1.2 Төслийн үндэслэл**

Монгол улсын Засгийн газраас Аялал жуулчлалын салбарын хөгжлийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэж, тогтвортой хөгжлийг ханган тус салбарын олон улсад өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор Аялал жуулчлалын үндэсний хөтөлбөрийг тогтоолоор баталсан. 2016-2025 оны хооронд тус хөтөлбөрийн хөгжүүлэх хөтөлбөртэй уялдуулна.

**1.3 Төслийн байршил:**

“Цэнхэрийн хөндий ”ХХК-ийн Аялал жуулчлалын цогцолбор нь Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэр болох Богдхан уулын ДЦГ-ын Түргэний аманд байрлана. Талбайн хэмжээг 107483.0 м2 байхаар төлөвлөжээ.

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн ерөнхий мэдээлэл

| | |
|---|---|
| Төсөл хэрэгжүүлэгчийн нэр: | “Цэнхэрийн хөндий ” ХХК |

| | |
|---|---|
| ААН-ийн УБД, РД: | УБД: 9011688009 РД: 6208592 |
| Одоо ашиглаж буй хэлбэр : | Одоогийн байдлаар үйл ажиллагаа явуулж эхлээгүй байна. |
| Газрын зориулалт: | БОАЖС-ын 2021 оны 10 сарын 14-ны өдрийн А328 тоот тушаал үндэслэн 107483 мкв газрыг Аялагч, зөвшөөрөл бүхий хүн түр буудаллах, отоглох зориулалтаар зохих журмын дагуу барьсан орон байрыг ашиглах зориулалттай Богдхан Уулын ДЦГ-ын Түргэний аманд 5 жилийн хугацаатай олгосон байна. |
| ААН-ийн албан ёсны хаяг: | УБ, Хан-Уул, 16-р хороо, буянт ухаа 6, 251 тоот Утас: 89190197 |

Хүснэгт 2. Газарзүйн солбицол

| **№** | **Latitude** | **Longitute** |
|---|---|---|
| **1** | *640038.70* | *5294555.10* |
| **2** | *640388.46* | *5294890.71* |
| **3** | *640544.06* | *5294727.59* |
| **4** | *640184.39* | *5294395.72* |




*Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн байршлын тойм зураг*



*Зураг 2. Төслийн талбайн байршлын зураг*




*Зураг 3. Төслийн талбайн ерөнхий төлөвлөгөө*

**1.4 Төслийн товч тодорхойлолт, хүчин чадал :**

“Аялал жуулчлалын цогцолбор” нь гадаад, дотоодын амрагч, жуулчдыг хүлээн авч, эрүүл цэвэр орчинд үйлчилнэ. Нэг удаа 80-250 хүн хүлээн авах хүчин чадалтай. Тус төсөл нь жилийн 4 улиралд ажиллана.

- А загварын амралтын байр -43ш
- Б загварын амралтын байр -35ш
- С загварын амралтын байр -2ш
- Клубхаус- 1ш
- Ногоон байгууламж -5555.6мкв
- Цахилгааны дэд өртөө
- Цэвэрлэх байгууламж, хог хаягдлын цэг
- Гүний худаг
- Хүүхдийн тоглоомын талбай
- Спорт талбай
- Машин зогсоолТөслийн үндсэн байгууламжууд:

Амралтын 2 давхар байр

| | |
|---|---|
|  | 3 төрлийн загвар бүхий 79 ширхэг амралтын байр байна. |
| Худаг | |
|   | Цогцолборын хэмжээнд нийт 2 худаг байрлана. Уулын бэлд байрлах тул худаг гүн 90-100 метр гүн ухаж худаг гаргах төлөвлөгөөтэй байна. Цогцолборыг усаар хангах 10тн-ын танканд усаа хуримтлуулж ус түгээх pvc хоолойгоор хуваарилагдах ба усны хоолой нь 150-н гипсэн хоолойгоор хийгдсэн pvc материалаар хөлдөлтөөс хамгаалдаг байна. |
| Асфальтан зам болон явган хүний зам | |
|  | Төслийн талбайд автомашины зам болон явган хүний замыг сайн шийдэх тул шороон замаас үүдсэн хөрс ургамлын талхагдал багатай байна гэж үзэж байна. |
| Гэрэлтүүлэг | |
|  | Явган хүний замын гэрлүүд нь оройн 21:00-05:00 хүртэл ажилладаг автомат тохируулгатай эрчим хүчинд хэмнэлттэй нарны хавтан бүхий гэрэл ашиглана. Төслийн талбайн явган хүний замын хажууд байрлах намхан гэрлүүд нь нарны эрчим хүчийг ашигладаг давуу талтай. |

Ажиллах хүч: Зочин угтах-3, Өрөө үйлчилгээ-5, Аж ахуй-3, Ресторан-6, Гал тогоо-6, Удирдлага-4. Нийт 27 хүний бүрэлдэхүүнтэй ажилладаг.

**1.5 Төсөл хэрэгжих орчны дэд бүтцийн хөгжлийн байдал**

**1.5.1 Цахилгаан хангамж** – Цахилгаан хэрэглээгээ нэгдсэн сүлжээ буюу “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ХХК-ний өндөр хүчдэлийн шугамаас трансформатор байгуулсны үндсэн дээр цахилгааны эх үүсвэр авч төслийн шаардагдах газрууд руу далд холболтоор хүргэснээр төслийн өдөр тутмын цахилгаанаар хангаж байна.

Амралтын байрны доторх цахилгаан холболтыг орос, германы монгол улсын стандарт болон ISO 9002 стандартын шаардлага хангасан техник тоног төхөөрөмжөөр холбож тоноглосон. Цогцолбор төвийн хашаанд гэрлийн шон, харуулын байранд прожекторыг тус тус байрлуулж гэрэлтүүлнэ. Мөн сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийг давхар ашиглахаар төлөвлөж байна.

Тус төслийн хүрээнд эрчим хүч татуулахдаа дараах нөхцөлүүдийг бүрэн хангасан байх шаардлагатай. Үүнд:

Харьяа Хэрэглэгчдэд үйлчлэх төвд биеэр ирж цахилгаан хангамжийн 220В, 0.4 кВ түүнээс дээш хүчдэлийн сүлжээнд шинээр холбогдох өргөдлийг бөглөж, түүнд заагдсан бүрдүүлэх материалыг “Нэг цэгийн үйлчилгээ”–ний төвд бүрдүүлэн өгч бүртгүүлнэ.

- Өргөдөл
- Аж ахуй нэгжийн гэрчилгээний хуулбар
- Газрын гэрчилгээ,
- Газрын байршлын кадастрын зураг,
- Архитектур төлөвлөлтийн даалгавар, эх зураг гэх мэт-г бэлтгэнэ. Тодруулах хуудсыг үнэн зөв бүрэн бөглөсөн байх шаардлагатай.

Өргөдлийг хүлээн авснаар аж ахуй нэгж байгууллага нь нэмэлтээр шаардлагатай бичиг баримтуудыг бүрдүүлнэ. Үүнд:

| № | 380В | 220В |
|---|---|---|
| 1 | Техникийн нөхцөл | Техникийн нөхцөл |
| 2 | Холболтын протокол | Газардуулгын протокол /Орон сууцны болон ерөнхий шитнээс холбогдсон бол шаардлагагүй/ |
| 3 | Газардуулгын протокол | Тоолуурын гэрчилгээ |
| 4 | Тоолуурын гэрчилгээ | Байгууллагын гэрчилгээний хуулбар |
| 5 | Гүйдэл, хүчдэлийн трансформаторын гэрчилгээ | Харилцах утасны дугаар |
| 6 | Газрын гэрчилгээ, кадастрын зураг, үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний хуулбар | Газрын гэрчилгээ, кадастрын зураг, үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний хуулбар |
| 7 | Байгууллагын гэрчилгээний хуулбар | |
| 8 | Харилцах утасны дугаар | |

**1.5.2 Цэвэр усан хангамж** - Гэрээтээр гүний худгаас зөөврөөр хангахаар төлөвлөж байна. Худгийн пасспорт, усны шинжилгээ, худаг гаргах зөвшөөрөлийг хавсралтаар оруулав.

Зөвлөмж:

- Төсөл хэрэгжих талбайд худаг гаргахдаа холбогдох шатны байгууллагаас зөвшөөрөл авч усны мэргэжлийн байгууллагаар худаг гаргуулан ус дамжуулах шугамын оролт тус бүр дээр тоолуур суулгах, ус ашиглах зөвшөөрөл, гэрээ, дүгнэлт гаргуулан цаашид ажиллах шаардлагатай.
- Төсөл хэрэгжих эзэмшил болон хариуцан хамгаалах талбайг үерийн болон гадаргын усны урсцаас хамгаалах зорилгоор далан байгуулах, эвдэрсэн тохиолдолд засварлах
- Үерийн уснаас хамгаалах даланг төслийн барилга байгууламжийн зураг төсөлд тодорхой тусгуулж хэрэгжүүлэх,

Тус төслийн хүрээнд усан хангамж хэрэглэхдээ дараах нөхцөлүүдийг бүрэн хангасан байх шаардлагатай. Үүнд:

- Өргөдөл, албан хүсэлт
- Иргэний үнэмлэх, Аж ахуй нэгжийн гэрчилгээний хуулбар
- Гүний худаг ашигладаг бол Худгийн зөвшөөрөл, худгийн паспортын хуулбар
- Танилцуулга, Байгууллагын танилцуулга
- Дүгнэлт- Туул голын сав газрын захиргаа, эсвэл байгаль орчин аялал жуулчлалын яамны дүгнэлтийн хуулбар
- Кадастрын зураг

Төслийн багт байнгын 27 ажилчинтай байна. Ажилчид кемпэд байрлаж, унд ахуйн усны хэрэглээг ариутгах татуургын системээр холбогдсон өөрийн гүний худгаас хангах бөгөөд ундны усанд сар бүр эрдэсийн болон бактертологийн шинжилгээ хийж, хяналт тавьж байх шаардлагатай.

“Байгаль орчин, Аялал жуулчлалын сайдын 2015 оны 7 сарын 30-ны өдрийн А/301 тушаалаар батлагдсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм”-ын 14 дүгээр хавсралт “Нийтийн болон ахуйн үйлчилгээний газруудын ус хэрэглээний норм”-д зааснаар амралт сувиллын газарт 1 амрагчийн хоногийн дундаж усны хэрэглээ нь 180 л болно.

Хүснэгт 3. Ахуйн ундны усны тооцоо

| **№** | **Үзүүлэлтүүд** | **Норм, л/хоног** | **Хамрах нэгж** | **Усны зарцуулалт** | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хоногт хэрэглэх ус $м^3$/хоног | Жилд ажиллах хоног | $м^3$/жил |
| **1** | Ахуйн усны хэрэглээ | 180 | 27хүн | 4.86 | 365 | 1773.9 |
| **2** | Амрагчид | 180 | 250хүн | 45.0 | 365 | 5256 |
| **3** | Ногоон байгууламж усалгаа | 40л/1ш | 1000ш | 40.0 | 24 | 960.0 |
| **Нийт** | | | - | 449.86 | 365 | *7989.9* |

Ногоон байгууламжид ашиглах ус: Ерөнхийлөгчийн тэрбум мод тарих хөдөлгөөний хүрээнд 1000 ширхэг мод тарьж ногоон байгууламж байгуулахаар төлөвлөсөн. Ургамалжуулахад хялбар, арчилгаа бага шаардах болон зардал тухайн талбайн үндсэн ургамалжилтын хэв шинжийг тооцон шинэс, нарс тарихаар төлөвлөсөн. Иймээс ногоон байгууламжийн усалгааг шилмүүст модны нэг удаагийн усалгаагаар буюу нэг суулгацыг нормын дагуу буюу 40 литр, ургамлын ургалтын хугацаанд буюу 4-10 сарын хугацаанд сард 4 удаа, жилд нийт 24 удаа усалгаа хийнэ.

1000 ш шинэс, нарс суулгац*0.04 м$^3$ ус* 24 удаа = 960.0 м$^3$

“Байгаль орчин, Ногоон хөгжил, Аялал жуулчлалын сайдын 2015 оны 7 сарын 30-ны өдрийн А/301 тушаалаар батлагдсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм”-ын 13 дугаар хавсралт “Зүлэгжүүлэлт, зам, талбайн усалгааны норм”-д зааснаар нэг ширхэг суулгацын усалгааны горим 40.0 л байна.

**1.5.3 Дулаан хангамж** – Уурын зуухаар нам даралтат панелин пааран халаагуур ашиглана. Тус уурын зууханд байгалв орчинд ээлтэй галлагааны зуух ашиглана. Цаашид төвийн дулааны шугамд холбогдох боломжтой байдлаар хосолмол халаалтын шийдлийг эрэлхийлж байна.

Төсөл хэрэгжүүлэгч нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 12-р сарын 01-ны өдрийн А/331”Аргачлалд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тушаалын дагуу хүлэмжийн хийг бууруулах зорилгоор эрчим хүчний шийдлийг байгальд ээлтэй технологи ашиглаж халаалт, дулааны асуудлыг шийдвэрлэх боломжийг төсөлд тусгасан эсэх гэсэн шаардлагад нийцүүлэн дараах шийдлүүдийг тусгаж байна.



**Зураг 2. Усны нөөцийн сав, Цахилгаан тоолуурын самбар, Ус халаагч бойлероор шийднэ.**

Харилцаа холбоо – Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь үүрэн телефоны бүхий л сүлжээ ашиглах боломжтой бөгөөд үйл ажиллагаандаа дотоод сүлжээгээр барилгын автомат хяналтын систем, дохиолол хамгаалалтын системийг ашиглана. Төсөлд агааржуулалт, кабелийн телевиз зэргийг хамруулж иж бүрэн автомат сүлжээ бий болгоно. Мөн цогцолборын удирдлагын системд зориулан ажиллагсадтайгаа холбогдох явуулын станцыг суурилуулна.

Хаягдал бохир усны шийдэл – "Эколос" ХХК-ийн ОХУ-ын компани болох "Юнилосс" ХХК-ийн оруулж ирдэг орчин үеийн дэвшилтэт технологи бүхий "Топас" бага оврын цэвэрлэх байгууламж нь 3 хүнийхээс эхлээд 300 хүний хүчин чадалтай 100 гаруй төрлийн бага оврын бохирын станцууд суурилуулахаар төлөвлөж байна. [1]

Төсөл хэрэгжүүлэгч нь "Байгаль Орчин, Аялал Жуулчлалын сайд"-ын 2017 оны 12 сарын 01-ний өдрийн А/331 тоот тушаалын дагуу байгаль орчинд халгүй, хөрсний бохирдол үүсгэдэггүй ариун цэврийн байгууламж, төслийн цар хүрээнээс хамааран бага оврын цэвэршүүлэх байгууламж байгуулах шаардлагыг хангаж байна.













Тусгай хамгаалалттай газар нутаг дахь эко аялал жуулчлалын зориулалттай байр сууц. Үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага." (MNS 6426:2013) стандартын 5.6.4-т зааснаар эко байр сууцны үйлчилгээнд энгийн нүхэн жорлонг ашиглахгүй ба байгальд ээлтэй технологи бүхий био жорлонтой байна.

Зөвлөмж:

Бохир усны цооногийг захын объектоос 20 метр, задгай гол, нуурын эргээс 30 м-ээс багагүй зайд байрлуулах,

Бохирын цооногт ариутгал, халдваргүйжүүлэлтийг ариутгалын бодис болон био бэлдмэл хэрэглэх,

- Бохир ус дамжуулах хоолойн холбооснуудаар ус алдагдаж байгаа эсэхийг үе үе хянах, тухай бүр нэн даруй засвар хийх.

[1] Эколос ХХК-ийн хувийн пэйж хуудаснаас

Зам харилцаа – Тус төсөл нь Богдхан уул, Түргэний амны бэлд байрлах тул зам харилцаа сайн хөгжсөн юм.

Зөвлөмж: Төсөл орчмын талбай, автомашины зогсоолыг хатуу хучилттай болгох, мөн төслийн газраас төв зам хүртэлх шороон замыг хатуу хучилттай болгохыг зөвлөж байна.

Ариун цэврийн өрөө – Тус төсөл нь нэгдсэн дотоод ариун цэврийн өрөө гаргаж хангадаг, хаягдал бохир усыг орчин үеийн хамгийн сүүлийн байгаль орчинд хор нөлөөгүй дэвшилтэт технологи хэрэглэнэ.

Төсөл хэрэгжүүлэгч нь “Байгаль Орчин, Аялал Жуулчлалын сайд”-ын 2017 оны 12 сарын 01-ний өдрийн А/331 тоот тушаалын дагуу байгаль орчинд халгүй, хөрсний бохирдол үүсгэдэггүй ариун цэврийн байгууламж, төслийн цар хүрээнээс хамааран бага оврын цэвэрлэх байгууламж байгуулах шаардлагатай.

Төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөж буй хугацаа

“Цэнхэрийн хөндий” ХХК-ийн “Аялал жуулчлалын цогцолбор” байгуулах төсөл нь 2025 онд эхлэх бөгөөд 2028 онд барилга, байгууламж бүрэн баригдаж дуусах ба жилийн дөрвөн улиралд аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулна.

## 1.6 Тэрбум мод

Тус “Цэнхэрийн хөндий ” ХХК-ийн “Аялал жуулчлалын цогцолбор” төслийн хүрээнд 2024-2028 онд тэрбум мод аяны хүрээнд нийт 1000ш мод тарихаар төлөвлөж өглөө.

**Хүснэгт 4. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд дараагийн 5 жилд тарих модны тооцоолол**

| Он | 2024 он | 2025 он | 2026 он | 2027 он | 2028 он | Нийт |
|---|---|---|---|---|---|---|
| Тарих модны тоо | 200 | 200 | 200 | 200 | 200 | 1000 |

# ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

## 2.1 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний цар хүрээ

### *2.1.1 Менежментийн төлөвлөгөөний зорилго, зорилт*

БОМТ-ний гол зорилго нь аялал жуулчлал, үйлчилгээ үйл ажиллагааны хүрээнд 2025 онд хэрэгжүүлэх байгаль орчны хяналт, хамгааллын ажлыг багцалж эрх бүхий байгууллагаар батлуулах, гүйцэтгэлийг хангуулж хуульд заасан хугацаанд хэрэгжилтийг тайлангахад оршино. БОМТ үндсэн зорилгынхоо хүрээнд 2025 онд дараах үндсэн ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

2.1.1.1 Үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах
2.1.1.2 Төслийн талбайн орчинд ногоон бүс тохижуулах
2.1.1.3 Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж осол эрсдлээс сэргийлэх арга хэмжээ авах
2.1.1.4 Хог хаягдлын оновчтой менежмент хэрэгжүүлэх
2.1.1.5 Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх
2.1.1.6 Байгаль орчны хамгаалахад удирдлагын оновчтой бодлого төлөвлөж хэрэгжүүлэх
2.1.1.7 БОМТ-ний биелэлт, хамгаалалтын захиргаатай байгуулсан гэрээний үүргийн биелэлтийг орон нутагт тайлагнах зэрэг ажил болно.

### *2.1.2 БОМТ-ний хамрах хүрээ*

Төслийн үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх 2025 оны БОМТ-г боловсруулахад БОАЖСайдын 2019 оны А/618 тоот тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, биелэлтийг тайлагнах” журмыг мөрдсөн ба төсөл нь “Үйлчилгээ”-ийн төслийн ангилалд хамаарна.

### *2.1.3 БОМТ-ний нийт зардал, түүний бүтэц*

2025 оны БОМТ-г хэрэгжүүлэхэд нийт 3.5 сая төгрөг төсөвлөгдөж байгаа ба түүний 32.0 хувийг сөрөг нөлөөг бууруулахад, 30.0 хувийг хог хаягдлын менежментийн арга хэмжээг хэрэгжүүлэхэд зориулна.

**Хүснэгт 7. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх нийт зардал**

| № | БОМТ-гөөр хийх ажил | Тооцсон зардал | |
|---|---|---|---|
| | | **төгрөг** | **хувь** |
| 1 | Сөрөг нөлөөг бууруулах | 1,100,000.00 | 32 |
| 2 | Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлт | - | - |
| 3 | Түүх, соёлын өвийг хамгаалах | - | - |
| 4 | Осол эрсдэлийн менемнтийг хэрэгжүүлэх | 1,000,000.0 | 30 |
| 5 | Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх | 1,000,000.0 | 30 |
| 6 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | 355,000.00 | 8 |
| 7 | Удирдлагын менежмент | Дотоод төсөв | - |
| 8 | БОМТ-г оршин суугчдад тайлагнах | Дотоод төсөв | - |
| **Нийт зардлын дүн** | | **3,500,000.0** | **100.0** |

## 2.2 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

“Хүннү баялаг тоонот” ХХК нь *Түр буудаллах, отоглох орон байр төслийн* үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах улмаар үүссэн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг төлөвлөлөө.

*Хүснэгт 5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө*

| Сөрөг нөлөө үүсгэх хүчин зүйл | Байгалийн бүрдэл хэсэг | Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл | Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ | Хэрэгжүүлэх цар хүрээ | Зардал сая.төг | Зардал сая.төг (1 жил) | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Баримтлах стандарт, аргачлал |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Үйл ажиллагааны үе шатанд | Агаарын чанар | • Бүтээн байгуулалтын үед тоосжилт бий болох | • Тоосжилтийн эсрэг ногоон тор татаж хамгаалах | Төслийн талбайд | 600.0 | | Төслийн хугацаанд | - |
| | Гүний ус | • Шатах тослох материал алдагдах үед авах яаралтай арга хэмжээг урьдчилан тодорхойлж урьдчилан сэргийлэх | • Spill kit асгаралтын иж бүрдэл байрлуулах https://hsct.mn/ | Төслийн хүрээнд | 500.0 | | Нэг удаа | Усны тухай хууль<br>MNS 2662-2002 |
| | Хөрсөн бүрхэвч | • Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийг арга зүйн дагуу хийгээгүй тохиолдолд хөрсөн бүрхэвч доройтох, нөхөн сэргэх чадвараа алдах | • Хөрсөн бүрхэвчийг талхагдахаас сэргийлж олон салаа зам үүсгэхгүй байх, нэгдсэн замын хөдөлгөөний сүлжээ зураг самбар тавих | Төслийн талбайд | Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөнд тусгасан | | | - |
| | Ургамлан бүрхэвч | • Үйл ажиллагаанаас ургамлан бүрхэвч доройтох | • Тэрбум мод тарих аяны хүрээнд мод тарих | Төслийн талбайд | Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөнд тусгасан | | | - |

| Сөрөг нөлөө үүсгэх хүчин зүйл | Байгалийн бүрдэл хэсэг | Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл | Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ | Хэрэгжүүлэх цар хүрээ | Зардал сая.төг | Зардал сая.төг (1 жил) | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Баримтлах стандарт, аргачлал |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Амьтны аймаг | • Төслийн талбайд зэрлэг амьтад нэвтрэх, улмаар гэмтэх, хог хаягдлаас хордох | • Төслийн талбайг хамгаалан хашаа байгуулах | Төслийн талбайн орчимд | Урсгал зардлаар | | Төслийн хугацаанд | • Амьтны тухай хууль |
| **Нийт** | | | | | **1100.0** | | | |

## 2.3 Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

| № | Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт | Нөхөн сэргээлтийн арга хэмжээ | Арга хэмжээний цар хэмжээ | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн зардал, төг | Нийт зардал мян.төг | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| 1. | | “ТЭРБУМ МОД” Үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих *(Тайлбар: “Улаанбаатар хотын 2014 онд тарилтад тэнцэх мод сөөгийн тарьц,* | Орон нутагт | ширхэг | 50 | 50000 | 50ш x 50000Т =**2500.0** | Жил бүр | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | *суулгацын ААНБ-ын судалгаа” “Тоонот байгаль” ТББ-ын үнийн дүнгээр авав.)* | | | | | | | |
| | Нийт | | | | | | Дотоод төсөв | | |

## 2.4 Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

Төслийн хэрэгжилтийн явцад ямарваа нэгэн түүх соёлын дурсгалт зүйл олдох үед холбогдох хууль тогтоомжинд заасны дагуу засаг захиргааны байгууллага болон холбогдох байгууллага болох ШУА-ийн Түүхийн хүрээлэнд даруй мэдэгдэж төслийн үйл ажиллагаг түр хугацаагаар зогсооно.

## 2.5 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

| № | Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл | Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Тоо хэмжээ | Нэгжийн зардал, мян.төг | Нийт зардал, төг | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| **1.** | Гал түймэр гарах | Гал унтраах хэрэгслээр төслийн кемпийг бүрэн хангах арга хэмжээ авах, галыг унтраах талаар тодорхой түвшинд бэлтгэлийг хангуулж байх | Нийт ажилчид | 5 | 200.0 | 1000.0 | Жил бүр | Галын аюулгүй байдлын тухай хууль 2015.12.04 нэмэлт шинэчилсэн найруулга |
| | **Нийт** | | | | | **1000.0** | | |

## 2.6 Хог хаягдлын менежмент

| № | Хог хаягдлын ангилал | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэмжих нэгж | Нэгжийн зардал, төг | Тоо хэмжээ | Нийт зардал, мян.төг | Хэрэгжүүлэх хугацаа | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| 1. | Ахуйн | Дүүргийн хот тохижуулах газартай гэрээг сунгаж ахуйн хог хаягдлыг тогтмол зайлуулах, Хог хаягдлын төлбөрийг цаг тухай бүрд төлөх | Хог хаягдлын түр хадгалах цэг | - | 300.0 | 2 | 1000.0 | 2025 оны 06 сард | Хог хаягдлын тухай шинэчилсэн хууль 2017.05.12 |
| 2. | Шингэн | Байгальд ээлтэй ариун цэврийн төв- Бохир соруулах гэрээ байгуулж тогтмол соруулж байх | Бохир түр хадгалах цэг | - | - | - | - | 2025 оны 06 сард | Агааржуулалттай сайжруулсан нүхэн жорлон Өрхийн нүхэн жорлонгийн MNS 5924:2015 стандарт |
| | Нийт | | | | | | 1000.0 | | |

## 2.7 Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр

| № | Хянах үзүүлэлтүүд | Хяналт шинжилгээ хийх байршил | Хяналтын давтамж | Шаардагдах зардал (урьдчилсан мян.төг) | Баримтах арга, аргачлал, стандарт, шаардлагууд |
|---|---|---|---|---|---|
| 1 | Агаарын чанар:<br><br>Агаарын тоосны (TSP, $PM_{10}$, $PM_{2.5}$) шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх | Төслийн талбайн авто зогсоол,<br>Ухашны салхин доод талд | Тоосны хяналт:<br>жилд 1 удаа<br>9 сард<br><br>Агаарын найрлага:<br>жилд 1 удаа<br>9 сард | 120.0 төгрөг зарцуулна. | MNS 4585-2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага,<br>MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага,<br>MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга<br>MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга, |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Агаарын бохирдлын ($NO_2$, $SO_2$, CO, Тоос) шинжилгээ хийлгэж байх. БОШТЛ-ын багажаар. | | | | MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга,<br>MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга |
| 2 | Усны хяналт шинжилгээ:<br>Усны чанар: pH, ууссан нийт давс (жингийн аргаар), нийт хатуулаг (CaCO3), Ca, Mg, Na, K, үнэр, өнгө, нүүрсустөрөгчид | Унд ахуйн уснаас | Жил бүр 9 сард | жилд 1цэг = 110.0 төгрөг<br><br>“Нарт шуун лаборатори”-ийн 2025 оны тариф | MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж<br>MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага<br>MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж<br>MNS 13.060.50 Усны чанарын стандарт<br>MNS 0900 : 2010 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт |
| 3 | Хөрсний төлөв байдал, бохирдол:<br>Хөрсний морфологи бичиглэл, pH, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент ($NO_3$, $P_2O_5$, $K_2O$), хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд, кадьми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайр | Төслийн талбайд | Жил бүр 9 сард | Нийт 125.0 төгрөг<br><br>“Нарт шуун лаборатори”-ийн 2025 оны тариф | MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга,<br>MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга,<br>MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга,<br>MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга<br>MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага<br>MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга<br>MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга |

| | | |
|---|---|---|
| Төслийн байгаль орчны хяналт шинжилгээний ажлын тухайн жилийн нийт зардлын дүн | 355.0 | |

**2.8 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө**

| № | Төлөвлөсөн арга хэмжээ | Урьдчилан тооцсон төсөв | Хэрэгжүүлэх хуваарь | | | Хариуцсан албан тушаалтан | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 2025 он | | | | |
| | | | Сар 03 | Сар 09 | Сар 11 | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Хогны гэрээ сунгах, хогны гэрээний дагуу төлбөр төлөх | - | захиалга | Явцтай танилцах | хүлээлцэх | ХАБЭА | Хамгаалалтын захиргаа, БОУАӨЯ |
| | Нийт | Урсгал зардалд оруулав. | | | | | |

**2.9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө**

| № | БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнахад оролцогч талууд | Тайлагнах хэлбэр | Мэдээллийн агуулга | Зохион байгуулах хугацааны тов | Тайлагнах зардал, төг | Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан | Зохион байгуулах газар |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | 2025 оны БОМТөлөвлөгөөг танилцуулах, батлуулах | Цаасан, цахим | Тухайн онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө | 2025.04 | - | ХАБЭА | Хамгаалалтын захиргаа, БОУАӨЯ |
| 2 | 2025 оны БОМТөлөвлөгөөний дагуу хийгдсэн ажлыг тайлагнах | Цаасан, цахим, зургаар | Тухайн онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний | 2025.11 | - | ХАБЭА | Хамгаалалтын захиргаа, БОУАӨЯ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | биелэлт хэрэгжилтийн үр дүнгийн мэдээ | | | | |
| | Нийт | | | | Урсгал зардалд оруулав. | | |

МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ

Арцатын 624, 23 дугаар хороо,
Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17100
Утас: 26 61 71, Цахим шуудан: contact@met.gov.mn,
Цахим хуудас: www.met.gov.mn

2024. 07.31 № 11/3497

танай ______ -ны № ______ -т

ЦЭНХЭРИЙН ХӨНДИЙ ХХК-д

Богдхан уулын дархан цаазат газрын хязгаарлалтын бүсийн Түргэний аманд байршилтай танай компанийн ашиглаж байгаа 107483 кв.м газар нь тусгай хамгаалалттай газрын кадастрын мэдээллийн санд бүртгэлтэй, бусад газар ашиглагч нарын газартай, ой болон усан сан бүхий газрын онцгой хамгаалалтын бүстэй давхцалгүй болно.

Байршлын зурган мэдээллийг хавсаргав.

Хавсралт 1 хуудастай.

САЛБАРЫН ХЯНАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА Б.МӨНХТОГТОХ

15240013

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ**

# УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ НУТАГ ДЭВСГЭРТ ГАЗАР АШИГЛАХ ХҮСЭЛТ ГАРГАЖ БУЙ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ГАЗРЫН БАЙРШЛЫН ЗУРАГ

**ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР**

Хүсэлтийн утга: Лавлагаа
Хүсэлт гаргагч: Цэнхэрийн хөндий ХХК
Газрын хэмжээ: 107483 м2
Газрын байршил: Богдхан уулын ДЦГ, Түргэний ам
Тайлбар: БОАЖ-ын сайдын 2021/10/14-ний өдрийн А/328 дугаар тушаалаар эрх олгосон.
Ой болон усан сан бүхий газрын онцгой хамгаалалтын бүстэй давхцалгүй болно.




ТХГНБЗГ

1 см = 126.72 м — 0 70 140 280 420 560 м — 1:12,672

Date: 7/19/2024

ЦЭНХЭРИЙН ХӨНДИЙ ХХК-д


МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ

Арцатын 624, 23 дугаар хороо,
Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17100
Утас: 26 61 71, Цахим шуудан: contact@met.gov.mn,
Цахим хуудас: www.met.gov.mn


2024.07.24 № 12/3392.
танай ____________-ны №____________-т

Ерөнхий үнэлгээний дүгнэлт
хүргүүлэх тухай

Танай байгууллагаас ирүүлсэн Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутагт Богдхан уулын ДЦГ-ын Түргэний аманд хэрэгжих “Аялал жуулчлалын цогцолбор”-ийн төсөлд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 58 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх журам”-д заасан аргачлалын дагуу байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийж, уг төсөлд батлагдсан аргачлалын дагуу байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай гэж үзэв.

Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудаст заасан нарийвчилсан үнэлгээний явцад тодруулах асуудлууд, онцгойлон анхаарах чиглэлийг харгалзан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэж 2025 оны 1 дүгээр улиралд багтаан тус яаманд ирүүлэхийг үүгээр мэдэгдье.

Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудсыг хавсаргав.

Хавсралт 7 хуудастай.

ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ Г.ЭНХМӨНХ

9024070681 9085084 СБТ-25823

152400038

## ҮНЭЛГЭЭНИЙ ХҮСЭЛТ, БАРИМТ БИЧИГ ХҮЛЭЭН АВАХ МАЯГТ

***Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, хаяг:*** "Цэнхэрийн хөндий" ХХК, Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 16-р хороо, буянт ухаа 6, 251 тоот, РД: 6208592;

***Холбоо барих утас:*** 89190197;

***Төслийн нэр:*** "Аялал жуулчлалын цогцолбор"-ын төсөл;

***Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, байршил:*** Богдхан уулын ДЦГ-ын Түргэний аманд хэрэгжинэ;

| Баримт бичгийн нэр | Шаардлагатай эсэх | Шаардлага хангасан эсэх | Тайлбар |
|---|---|---|---|
| Төсөл хэрэгжүүлэгчийн ерөнхий үнэлгээ хийлгэх тухай хүсэлт /албан бичиг/ | Тийм | + | 2024 оны 07 дугаар сарын 03- ны өдрийн албан бичиг, **/О77-2407-000032/** |
| Эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан ТЭЗҮ, зураг төсөл | Тийм | + | 2024 оны зураг төсөл |
| Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хөтөлбөрт тусгагдсан эсэх /газрын зөвшөөрөл, ТХГН-т байрлах бол Хамгаалалтын захиргааны санал/ | Тийм | + | /-/ |
| Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлын тодорхойлолт | Үгүй | | |
| Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан | Тийм | + | Байгаль орчны үнэлгээний "Төгрөг баян хангай" ХХК боловсруулсан. |
| Төсөл хэрэгжих орчны тойм зураг (топо, сансрын) | Тийм | + | |
| Тухайн сум, дүүргийн Засаг даргын тодорхойлолт | Тийм | + | Богдхан Уулын ДЦГ-ын хамгаалалтын захиргааны 2024.05.06-ний өдрийн 01/698 тоот албан бичиг |
| Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар /нотариатаар батлуулсан байх/ | Тийм | + | РД: 6208592; |

**Тусгай тэмдэглэл:**

"ЦЭНХЭРИЙН ХӨНДИЙ" ХХК-ийн "Аялал жуулчлалын цогцолбор" төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан"-г Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын "Аргачлал батлах тухай" 2014 оны А-117 дугаар тушаалын хавсралтын дагуу хийлгэх шаардлагатай гэж үзлээ.

**Ерөнхий үнэлгээ хийлгэх хүсэлт, материалыг хянасан:**

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ШИНЖЭЭЧ** **З.АЗЖАРГАЛ**

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ**
**ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН**
**ХУУДАС**

**2024 оны 07-р сарын 17** **Улаанбаатар хот**

**Төслийн дугаар** **Дугаар 2024/А3-59**

***Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, хаяг:*** "Цэнхэрийн хөндий" ХХК, Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 16-р хороо, буянт ухаа 6, 251 тоот, РД: 6208592;
***Холбоо барих утас:*** 89190197;
***Төслийн нэр:*** "Аялал жуулчлалын цогцолбор"-ын төсөл;
***Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, байршил:*** Богдхан уулын ДЦГ-ын Түргэний аманд хэрэгжинэ;
**Орон нутгийн санал:** Богдхан Уулын ДЦГ-ын хамгаалалтын захиргааны 2024.07.03-ний өдрийн 01/698 тоот албан бичиг, Е-Монголиа цахим бүртгэлийн 2024 оны 05 дугаар сарын 08-ний өдрийн А24/07 албан бичиг, **О77-2407-000032** хүсэлтийг тус тус үндэслэв.
**Газарзүйн байршил, координат**:

| Д/д | Уртраг | Өргөрөл |
|---|---|---|
| 1. | 106.52.17.850E | 47.47.15.564N |
| 2. | 106.52.11.037E | 47.47.20.838N |
| 3. | 106.52.28.233E | 47.47.31.431N |
| 4. | 106.52.35.515E | 47.47.26.026N |

| | **Ерөнхий үнэлгээний гол шалгуурууд** | **Нийцсэн** | **Нийцээгүй** | **Нарийвчилсан үнэлгээ хийх шаардлагатай** | **Үндэслэл тайлбар** |
|---|---|---|---|---|---|
| Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийн нийцэл | Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа байгаль орчныг хамгаалах болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль тогтоомжийн холбогдох заалт | Тийм | | | Нарийвчилсан үнэлгээний явцад хууль тогтоомжийн нийцлийг нарийвчлан тодорхойлох |
| Төрийн бодлого, шийдвэрийн нийцэл | Төрөөс баримтлах бодлогын баримт бичиг, Стратегийн үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийн холбогдох заалт | Тийм | | | |
| Төслийн байршил, түүнтэй холбогдох шалгуурууд | Хуулиар хамгаалагдсан газар нутаг байгаа эсэх (урсац бүрэлдэх эх, ойн болон усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, хилийн хамгаалалтын бүс, орон нутгийн | Тийм | | Тийм | Богдхан уулын ДЦГ-ын аялал жуулчлалын бүсэд |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | тусгай хамгаалалттай газар г.м) | | | | |
| | Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь хүний нөлөө, байгаль цаг уурын өөрчлөлтөд эмзэг, мэдрэмтгий эсэх | Тийм | | Тийм | |
| | Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, түүний ойр орчимд улс, орон нутгийн хэтийн хөгжилд ашиглахаар төлөвлөсөн, сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй газар байгаа эсэх | | | Тийм | |
| | Болзошгүй хуримтлагдах нөлөөлөл үүсгэх эсэх | | | Тийм | |
| Төслийн байгаль орчны нөлөөллийн урьдчилсан үнэлгээ | **Агаарын чанар** | | | | |
| | Бохирдуулагч болон аюултай, хортой бодис агаар мандалд ялгаруулах, эсэх | | | Тийм | |
| | Дуу чимээ, доргио чичиргээ, гэрлийн болон дулааны нөлөөлөл, цахилгаан соронзон цацраг үүсэх, эсэх | | | Тийм | |
| | 1.Төслийн явцад орчны бохирдлыг тооцож, үйл ажиллагаанаас агаарт үзүүлж болзошгүй нөлөөллийг тодорхойлох,<br>2.Төслийн үйл ажиллагаанаас гарах хатуу, шингэн хог хаягдлын байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тогтоож, арилгах, бууруулах, байгаль орчинд халгүй аргаар зайлуулах арга хэмжээг төлөвлөх, | | | | |
| | **Усан орчин** | | | | |
| | Гадаргын болон газрын доорх усны нөөцийн хомсдол үүсэх, эсэх | | | Тийм | |
| | Цэнгэг усны нөөцийг ашиглах, эсэх | | | Тийм | |
| | Гадаргын болон газрын доорх усанд бохирдол үүсэх, эсэх | | | Тийм | |
| | 1. Төслийн үйл ажиллагаанаас усны нөөц, горим чанарт үзүүлэх нөлөөллийг тогтоож, түүнд тавих хяналт, хугацаа, хөрөнгө зардлыг нарийвчилан тооцох;<br>2. Усны алдагдлыг багасгах, усыг хэмнэлттэй ашиглах технологийн хувилбарыг судалж, тайланд тусгах; | | | | |

3. Аялал жуучлалын үйл ажиллагаанаас гарч байгаа бохир усны хэмжээ, найрлагыг нарийвчлан тогтоож, түүнийг байгаль орчинд халгүйгээр зайлуулах цэвэршүүлэх, дахин ашиглах боломж, арга хэмжээ, түүнд шаардагдах зардлыг тооцох;
4. Төсөл хэрэгжиж байгаа нутаг дэвсгэр нь Усны тухай хууль, тогтоомж болон бусад хууль тогтоомжоор хориглосон хязгаарласан бүсэд орж байгаа эсэхийг тодорхойлж бүсийн дэглэмийг зөрчихгүй байх талаар зөвлөмж боловсруулж тайланд хавсаргах,

**Хөрсөн бүрхэвч**

| | | | | |
|---|---|---|---|---|
| Хөрсөн бүрхэвч эвдрэх, эсэх | | | Тийм | |
| Хөрс бохирдуулах эсэх | | | Тийм | |
| Хөрс доройтох, цөлжих эсэх | | | Тийм | |

1. Төслийн үйл ажиллагааны явцад хөрс, газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөлөл, түүнийг багасгах, арилгах, цөлжилт, хөрсний эвдрэлээс урьдчилан сэргийлэх арга зам, түүнд шаардагдах хөрөнгө зардлыг төлөвлөх;
2. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчид үүсэх бохирдлын эрсдэлтэй цэгийг нарийвчлан тогтоож шинжилгээнд хамруулах бохирдуулагч бодисын нэр төрлийг тодорхой тусгаж, түүнд шаардагдах хөрөнгө зардлыг төлөвлөх;
3. Хатуу, шингэн хог хаягдал, техник технологийн ашиглалтын явцад хөрс бохирдуулахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх;
4. Олон салаа зам гаргах, хөрс бохирдох, эвдрэхээс сэргийлэх, тогтсон нэг орц, гарцыг тогтоох;

**Ургамлан нөмрөг**

| | | | | |
|---|---|---|---|---|
| Ургамлан нөмрөг, ой мод өртөх эсэх | | | Тийм | Ургамлан нөмрөг өртөнө. |
| Ховор, нэн ховор ургамлын төрөл зүйлс өртөх, эсэх | | | Тийм | Нарийвчилсан үнэлгээгээр тодорхойлох |

1. Төслийн үйл ажиллагаа явуулахад өртөх талбайн ургамлын нэр төрөл, тархалтыг тогтоох, ховор болон нэн ховор ургамал байгаа эсэх талаар дүгнэлт гаргаж, хэрэв тэдгээр нь төслийн үйл ажиллагааны явцад өртөхөөр байвал түүнийг хамгаалах, болон шилжүүлэх, плантац байгуулах арга хэмжээ авах төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх түүнд шаардагдах хөрөнгө зардлыг төлөвлөх;
2. Эдэлбэр газрын орчны ногоон байгууламжийг бууруулахгүй сөрөг нөлөөлөлд өртүүлэхгүй үйл ажиллагаа явуулах, шаардлагатай газарт ногоон байгууламж байгуулах талаар мэргэжлийн түвшний зөвлөмжийг шаардагдах зардлын хамт боловсруулж, тайланд тусгах;
3. Төслийн үйл ажиллагааны улмаас сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй биологийн төрөл зүйлийн бүрэлдэхүүнийг нарийвчилан тогтоож, хамгаалах арга замыг цогц байдлаар шийдэхэд заавар, зөвлөгөө өгөх, тайланд тусгах;
4. Төсөл хэрэгжиж байгаа нутаг дэвсгэр нь Ойн тухай хууль, тогтоомж болон бусад хууль тогтоомжоор хориглосон хязгаарласан бүсэд орж байгаа эсэхийг тодорхойлж бүсийн дэглэмийг зөрчихгүй байх талаар зөвлөмж боловсруулж тайланд хавсаргах,

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **Амьтны аймаг** | | | | |
| | Зэрлэг амьтдын амьдрах орчинг доройтуулах, эсэх | | | Тийм | |
| | Ховор, нэн ховор амьтан өртөх, эсэх | | | Тийм | |
| | Төслийн үйл ажиллагааны улмаас амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг тодорхойлж, нөлөөлөлд өртөж болзошгүй биологийн төрөл зүйлийн бүрэлдэхүүнийг нарийвчилан тогтоож, амьтны гүйдлийн зам болон хамгаалах арга замыг цогц байдлаар шийдэх заавар, зөвлөгөө өгөх, тайланд тусгах; | | | | |
| Нийгмийн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ | **Нутгийн оршин суугчид** | | | | |
| | Газар эзэмших, ашиглах эрх зөрчигдөх, эсэх | | | Тийм | |
| | Нутгийн оршин суугчдын нийгмийн байдалд сөрөг нөлөөлөлтэй, эсэх | | | Тийм | |
| | Нөлөөлөлд өртөж болзошгүй төв, суурин газар байгаа, эсэх | | | Тийм | |
| | Нүүлгэн шилжүүлэх асуудал үүсэх, эсэх | | | Тийм | |
| | **Түүх, соёлын биет өв** | | | | |
| | Сөрөг нөлөөлөлд өртөх түүх, соёлын үнэт зүйлс бий эсэх | | | Тийм | |
| | Төсөл хэрэгжих бүс нутгийн түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээг холбогдох зардлын хамт тайланд тусгах; | | | | |
| | **Хүний эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөлөл** | | | | |
| | Нутгийн иргэд, оршин суугчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эсэх | | | Тийм | |
| | Төслийн бүх үе шатанд хүний эрүүл мэнд, амь насанд эрсдэл үүсэх эсэх | | | Тийм | |
| | Төслийн үйл ажиллагаа болон байгалийн гамшгаас үүдэн гарч болзошгүй ослын үнэлгээ хийж, ослоос сэргийлэх, түүнийг багасгах, арилгах арга хэмжээг тодорхойлж тайланд тусгана. | | | | |

**Нэгдсэн дүгнэлт:**

**Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлээр уг төсөлд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын “Аргачлал батлах тухай” 2014 оны А-117 дугаар тушаалын хавсралтын дагуу хийлгэн, нарийвчилсан үнэлгээний тайланг тус яаманд 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлж, шүүмж хийлгэн, шийдвэр гаргуулах шаардлагатай гэж үзлээ.**

**Онцгойлон анхаарах зүйлс:**

1. Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон Байгаль орчны сайдын 2010 оны 156 дугаар тушаалаар батлагдсан "Байгаль орчны хохирлын үнэлгээ, нөхөн төлбөр тооцох аргачлал"-ын дагуу төслийн үйл ажиллагаанаас ургамал, хөрс, амьтан, агаар орчинд учруулах хохирлыг байгалийн бүрэлдэл тус бүрээр тогтоож, улмаар тухайн газрыг эвдрэлд оруулснаар учирч болох хохирлыг урьдчилан тооцож нийлбэр үнэлгээ гарган төслийг хэрэгжүүлэх байгаль орчны хариуцлагын болон эдийн засгийн үндэслэлийг тодруулж дүгнэлт гаргах;
2. Төслийн үйл ажиллагааны явцад гарах ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдал, ашиглагдаж байгаа тоног төхөөрөмж, тусгай ангиллын хог хаягдлыг хүний эрүүл мэнд, байгаль орчинд халгүй аргаар цуглуулах, ангилан ялгах, дахин ашиглах, устгах, зайлуулах аргыг нарийвчлан тооцож, төслийн үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг болгон хог хаягдлыг байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүйгээр устгах, зайлуулах талаар зөвлөмж боловсруулах;
3. Зураг төсөлд өөрчлөлт оруулсан тохиолдолд дахин тодотгол хийлгэх;
4. БОННҮ-нд байгаль орчинд ээлтэй, олон улсын стандартад нийцсэн технологийг ашиглах талаар заавар, зөвлөмжийг боловсруулах; (Ариун цэврийн байгууламж, дулааны асуудал...)
5. Эдэлбэр газрын орчны ногоон байгууламжийг бууруулахгүй сөрөг нөлөөлөлд өртүүлэхгүй үйл ажиллагаа явуулах, шаардлагатай газарт ногоон байгууламж байгуулах төсөл боловсруулж, хэрэгжүүлэх;
6. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг 5 жилээр боловсруулж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг төслийн хүчин чадал, төслийн үйл ажиллагааны өрнөлтийн байдалтай уялдуулан тооцож, төлөвлөх;
7. Нарийвчилсан үнэлгээ хийх явцад уг төсөл хэрэгжиснээр байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх эерэг болон сөрөг нөлөөллийн талаар болон БОННҮ-ний ажлын тайланг төсөл хэрэгжих багийн ИНХ-аар хэлэлцүүлж, хурлын тогтоол, тэмдэглэлийг тайланд хавсаргах;
8. "Тэрбум мод" Үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулж, төсөл хэрэгжүүлэгчид танилцуулан нарийвчилсан үнэлгээний тайланд тусгах;
9. Нийгмийн нөлөөллийн асуудлыг тайланд нарийвчилан тусгах;
10. Газрын тусгай зөвшөөрөл тайланд хавсаргах

**Бусад зүйлс:**

1. Нарийвчилсан үнэлгээний тайланд шүүмж хийлгэн дүгнэлт, шийдвэр гаргуулах асуудлыг ерөнхий үнэлгээгээр тогтоосон хугацаанд хэрэгжүүлэх;
2. Ерөнхий үнэлгээнд заасан чиглэл, нөхцөл, болзлоос өөр үйл ажиллагаа явуулах болон төсөлд өөрчлөлт орох, эсхүл өргөтгөх, шинэ тоног төхөөрөмж, технологи нэвтрүүлэх бүрт Ерөнхий үнэлгээнд хамрагдаж байх;

| Ерөнхий үнэлгээ хийсэн: | Ерөнхий үнэлгээний үр дүнг зөвшөөрсөн: |
|---|---|
| **БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ШИНЖЭЭЧ** | **"ЦЭНХЭРИЙН ХӨНДИЙ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ** |
| **З.АЗЖАРГАЛ** | **П.НАЦАГДОРЖ** |

Хууль зүйн сайдын 2016 оны
А/204 дүгээр тушаалаар батлав.

# МОНГОЛ УЛС
# ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000145289

2017.07.28
/ Бүртгэсэн он,сар,өдөр /

9011688099
/ Хувийн хэргийн дугаар /

6208592
/ Регистрийн дугаар /

Цэнхэрийн хөндий Хязгаарлагдмал хариуцлагатай компани
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

| Шийдвэр | 1 | 2017.07.28 |
|---|---|---|
| / шийдвэрийн нэр / | / дугаар / | / он, сар, өдөр / |

| 8299 | Бизнесийн зөвлөгөө |
|---|---|
| / код / | / Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл / |

| | |
|---|---|
| / код / | / Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл / |

| Хугацаагүй | 1 | 10.0 |
|---|---|---|
| / хугацаа / | / гишүүдийн тоо / | / өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр / |

Улаанбаатар, Хан-Уул, 16-р хороо, буянт ухаа 6, 251 тоот, Утас1: 89190197, Утас2: , Факс:
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /

Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар Хуулийн этгээдийн бүртгэлийн газар
/ бүртгэсэн байгууллагын нэр /

5296722 1117141300

## Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

| Д/д | Нэмэлт өөрчлөлтийн агуулга | Бүртгэсэн | |
|---|---|---|---|
| | | Огноо | Ажилтан тэмдэг |
| 1 | Чулуунбат овогтой Ууганбаатар-г Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв. | 2017.07.28 | Ж.Аюуш |
| 2 | Рэнцэнсүрэн овогтой Дэлэг -г Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв. | 2017.08.08 | Б.Гэрэлзул |
| 3 | Улаанбаатар, Хан-Уул, 18-р хороо, хүннү-2222, 112 байр 602 тоот Утас1: 99070391, Утас2: , Факс: хаягийг шинээр бүртгэв. | 2021.09.30 | Э.Баточир |
| 4 | Хувьцаа эзэмшигч 1 нэмэгдэж 1 хасагдаж хувьцаа эзэмшигчийн тоо нийт 1 болж өөрчлөгдсөнийг бүртгэв. | 2021.09.30 | Э.Баточир |
| 5 | Идэрзуу овогтой Бямбадулам-г Гүйцэтгэх захирал -р сонгосон(томилсон)-ыг бүртгэв. | 2021.09.30 | Э.Баточир |
| 6 | Эцсийн өмчлөгч 1 иргэн бүртгэв. | 2021.09.30 | Э.Баточир |
| 7 | 8299 Бизнесийн зөвлөгөө үйл ажиллагааг хассаныг бүртгэв. 79110 Аялал, жуулчлалын агентлагийн үйл ажиллагаа үйл ажиллагаа шинээр бүртгэв. | 2021.09.30 | Э.Баточир |
| 8 | Улаанбаатар, Чингэлтэй, 6-р хороо, бага тойруу, 30, 45 тоот Утас1: 99111108, Утас2: , Факс: хаягийг шинээр бүртгэв. | 2023.05.16 | Б.Алтансүх |
| 9 | Хувьцаа эзэмшигч 1 нэмэгдэж 1 хасагдаж хувьцаа эзэмшигчийн тоо нийт 1 болж өөрчлөгдсөнийг бүртгэв. | 2023.05.16 | Б.Алтансүх |
| 10 | Пүрэвдорж овогтой Нацагдорж-г Гүйцэтгэх захирал -р сонгосон(томилсон)-ыг бүртгэв. | 2023.05.16 | Б.Алтансүх |
| 11 | Эцсийн өмчлөгч 1 иргэн бүртгэв. | 2023.05.16 | Б.Алтансүх |

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

*0001452 89*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ**

МОНГОЛ УЛС
ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР

**МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ
УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ НУТАГ
ДЭВСГЭРТ ГАЗАР АШИГЛАХ**

# ГЭРЧИЛГЭЭ

**Дугаар** 0211886

**"Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай" Монгол улсын хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх заалтыг үндэслэн Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 20 21 оны 10 дугаар сарын 14 өдрийн А/328 дугаар тушаалаар Улаанбаатар аймаг /хот/ Хан-Уул сум /дүүрэг/-ын нутагт орших Богдхан уулын ДЦГ тусгай хамгаалалттай газар нутгийн Түргэний ам нэртэй 107483.0 м2 га талбайг аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн түр буудаллах, отоглох, ажиглалт судалгаа хийх зориулалтаар зориулалтаар ашиглахыг "Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай" хуулинд заасан нөхцөл, журмын дагуу зөвшөөрч, энэхүү гэрчилгээг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын 6208592 тоот гэрчилгээ /регистр/-тэй Цэнхэрийн хөндий ХХК -д 5 жилийн хугацаагаар олгов.**

**Энэхүү гэрчилгээ нь газар ашиглалтанд оруулсан аливаа өөрчлөлт, сунгалтыг тэмдэглэх хавсралттай бөгөөд хавсралтгүй бол хүчин төгөлдөрт тооцогдохгүй.**

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ЯАМНЫ ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ НУТГИЙН УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА **Д.БАТМӨНХ**
**даргын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч**

20 21 оны 10 сарын 18 өдөр

**ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГТ ГАЗАР АШИГЛАХ 0211886 ТООТ ГЭРЧИЛГЭЭНИЙ ХАВСРАЛТ**

/Гэрчилгээгүй бол хүчингүй/

**Хоёр. Гэрчилгээгээр олгогдсон талбайн булангийн цэгүүдийн солбицлууд**

| № | Анхны солбицлууд, үндэслэл | Өөрчлөгдсөн солбицлууд, үндэслэл |
|---|---|---|
| 1. | Талбайн анхны солбицлууд<br><br>1 106° 52' 17.850" E 47° 47' 15.564" N<br>2 106° 52' 11.037" E 47° 47' 20.838" N<br>3 106° 52' 28.233" E 47° 47' 31.431" N<br>4 106° 52' 35.515" E 47° 47' 26.026" N<br>107483.0 квадрат метр<br><br>Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2021 оны 10 дугаар сарын 14-ны өдрийн А/328 дугаар тушаал, Хамгаалалтын захиргааны 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн № 1408 тоот саналыг тус тус үндэслэн олгов.<br><br>2021 оны 10 сарын 18-ны өдөр<br>Ой, ус, тусгай хамгаалалттай газрын кадастрын хэлтсийн дарга: Н.БАТЗАЯА<br><br>2021 оны 10 сарын 18-ны өдөр<br>Ой, ус, тусгай хамгаалалттай газрын кадастрын хэлтсийн мэргэжилтэн: Э.ЭРДЭНЭХҮҮ | |